



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/226

Мөрөн сум

“Бүх нийтээр мод тарих өдөр”-ийг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Монгол улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 63, 2021 оны 58 дугаар зарлигийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын санаачилсан “Мод тарьж ногоон суварга босгоё” аяны хүрээнд хаврын “Бүх нийтээр мод тарих” өдрийг 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн нэг сарын хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулсугай.

2.Суманд таригдсан болон одоо ургаж буй бүх модыг бүртгэн тоолж, суурь мэдээллийг гарган айл өрх, аж ахуй нэгж байгууллага, нийтийн эзэмшлийн талбайд мод тариулах, мод тарихад шаардагдах хар шороо, өтөг бууц, усалгаа, арчилгааны асуудлыг эзэнжүүлж шийдвэрлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.


3.Мод бэлтгэлийн ажил гүйцэтгэсэн ойн мэргэжлийн байгууллагуудын өөрийн хөрөнгөөр хийгдэх ойжуулалтын ажлыг ойг нөхөн сэргээх зориулалтаар нь хавар хийлгүүлэх, тарих хугацаа хоцорсон тохиолдолд бортоготой тарьцаар гүйцэтгүүлж хүлээж авах, хавар, намрын мод тарих ажилд өрх айлуудыг өргөнөөр хамруулж, Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлд заагдсан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

4.Мод, бутны сонголт, ач холбогдол, тарьж ургуулах арга технологи, бортоготой мод ургуулах талаар сурталчлах, сумдад таригдсан модны ургалт амьдралтын хувь, үр дүнг тооцож ажиллахыг сум дундын Ойн ангийн дарга, Байгаль орчин аялал жуулчлалын газрын дарга нарт тус тус даалгасугай.

5.Тэрбум мод үндэсний хөдөлгөөн, аймгийн Засаг даргын санаачилсан “Мод тарьж ногоон суварга босгоё” аяны үйл ажиллагааг албан байгууллагуудтай уялдуулан зохион байгуулж олон нийтийг мэдээ, мэдээллээр хангаж ажиллахыг албан байгууллагын дарга нарт үүрэг болгосугай.

6.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА



П. ЛХАГВАЖАВ

67120107:1

Захирамж 2024